

СААТУУЛАХ БАЙРНЫ ДЭГЛЭМ, ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлийн дагуу саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан хүнийг /цаашид “саатуулагдсан хүн” гэнэ/ хүлээн авч саатуулах шийдвэрийг хэрэгжүүлэх нэгжийг саатуулах байр /цаашид “саатуулах байр”/ гэнэ.

1.2. Саатуулах байрны үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Саатуулах ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль дээдлэх зарчмыг баримтална.

1.4. Хүнийг саатуулах тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдсэн хүчин төгөлдөр **шийдвэр** нь саатуулах байранд хүлээн авах үндэслэл болно.

Хоёр. Саатуулах байрны нөхцөл

2.1. Саатуулах байр нь халуун, хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалтын систем зэрэг ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйц орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.2. Саатуулах байр нь эмчийн үзлэг хийх, гал тогооны, бие засах, саатуулагдсан хүмүүсийн хувцас, биедээ авч яваа бичиг баримт, бусад эд зүйлийг хадгалах өрөөтэй байхаас гадна догшин хэрцгий авирласан, бусдын болон өөрийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах үйлдэл хийж болзошгүй хүнийг байлгах тусгаарлах өрөөтэй байна.

2.3. Саатуулах байр нь хүйтний улиралд 18°C-ээс доошгүй хэмийн дулаан, чийглэг нь 40-60 хувьтай байх ба гадна талаасаа агаар болон гэрэл орох салхивчтай, шөнийн цагт ашиглах унтраалга бүхий гэрэлтүүлэгтэй байна.

2.4. Саатуулах байрны өрөө нь саатуулагдсан нэг хүнд 2 ам.метрээс доошгүй талбай ногдох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.5. Саатуулагдсан хүнийг байрлуулах өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангахуйц шалтай, модон ор /наар/-той байх бөгөөд хүн тус бүрийг хөнжил, гудас, цагаан хэрэглэлээр хангасан байна.

2.6. Өрөөний цонх нь төмөр сараалжин хамгаалалттай байх ба хаалга нь саатуулагдсан хүн харагдахуйц сараалж бүхий төмөр бэхэлгээ, эсхүл хянах шагайвчтай, онгойхдоо нэг хүн багтах зайд хязгаарлагчтай, гадна талдаа түгжээтэй байна.

2.7. Саатуулах өрөөнүүдийн байршил нь эсрэг хүйсийн хүмүүсийг өөр хоорондоо харагдахгүй байхаар зохион байгуулагдсан байна.

2.8. Саатуулах өрөөнүүд болон хонгил, бусад шаардлагатай хэсэгт дуу, дүрсний бичлэг хийх боломжтой телехяналтын дуран байрлуулна.

2.9. Саатуулах байранд ариутгалын бодис бүхий чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр, их цэвэрлэгээг долоо хоног тутамд нэгээс доошгүй удаа тогтмол хийж, саатуулагдсан хүн солигдох бүрт хэрэглэсэн хөнжил, гудас, цагаан хэрэглэл зэргийг цэвэрлэж ариутгал хийнэ.

2.10. Саатуулах байрны гал тогоо нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахуйц байдлаар зөв зохион байгуулагдаж, ажил, үйлчилгээ явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, чанарын баталгаатай хүнсний зүйлээр хангагдсан байна.

2.11. Саатуулагдаж байгаа хүнийг хоногт 2-оос цөөнгүй удаа хооллох бөгөөд хоолны илчлэг нь 2200 килокалориос багагүй байна. Саатуулагдсан хүний хоолны талаар эмч тусгайлан заалт өгсөн бол түүнийг биелүүлнэ.

2.12. Саатуулагдсан хүн өвчтэй бол эмнэлэгт үзүүлж, эмчийн үзлэгээр заагдсан эмчилгээг хийлгэх буюу эмнэлэгт хэвтүүлэн энэ тухай саатуулсан байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ. Эмчилгээний зардлыг өвчтөн өөрөө хариуцна.

Гурав. Саатуулах байрны дэглэм

3.1. Саатуулах байр нь харуул, хамгаалалттай байх бөгөөд саатуулагдсан хүмүүс байрлах өрөө болон холбогдох бусад цэгүүд телекамерын хяналтад байна.

3.2. Саатуулах байранд насанд хүрсэн хүнийг насанд хүрээгүй хүнээс, эрэгтэйг эмэгтэйгээс, түүнчлэн халдварт өвчтэй нь эмчийн дүгнэлтээр тогтоогдсон хүмүүсийг бусад хүмүүсээс тусад нь байрлуулна. Хэрэв саатуулах эрх бүхий албан тушаалтнуудаас бүлэглэж зөрчил үйлдсэн хүмүүсийг тус тусад нь байлгах хүсэлт гаргасан бол түүнийг биелүүлэх арга хэмжээ авна.

3.3. Саатуулагдсан хүн сэтгэл гутралд орсон, амиа хорлох тухай амаар болон үйл хөдлөлөөр илэрхийлсэн, догшин, хэрцгий авирлан бусдыг заналхийлж байвал эмчийн хяналт дор аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, бусдаас тусгаарлах бөгөөд түүнд байнгын биечилсэн хяналт тогтооно. Тусгаарлах өрөөнд уг хүний орсон гарсан цаг, үйлдлийг нарийвчлан тусгасан тэмдэглэл хөтөлж, бүртгэлийн маягтад хавсаргана.

3.4. Саатуулах өрөөнд бүс, тэлээ, хөлийн ороолт, гутлын үдээс, хумсны хутга, хурц үзүүртэй эд зүйлс авч орох, утаат тамхи нэвтрүүлэх, татахыг хориглоно.

3.5. Саатуулах өрөөнд сонин, сэтгүүл, ном, ариун цэврийн хэрэглэл /сам, шүдний оо, сойз, саван, нүүр гарын алчуур гэх мэт/ шалгагдаж буй хэрэгт холбогдолтой бичиг баримт авч орохыг зөвшөөрнө.

3.6. Өдрийн цагт хуурай зайгаар ажилладаг бага оврын радио хүлээн авагч ашиглуулж болно.

3.7. Саатуулагдсан хүний хучлага, дэвсгэрийг өдрийн цагт хураан авч, шөнийн цагт тавьж олгоно.

3.8. Саатуулагдсан хүн өөрөө өрөөгөө цэвэрлэх тохиолдолд цэвэрлэгээний материалыг саатуулах байрнаас олгоно.

3.9. Саатуулах байранд саатуулагдсан хүн, түүнийг саатуулсан эрх бүхий албан тушаалтан, харьяа хяналтын прокурор, өмгөөлөгчөөс өөр хүн нэвтрүүлэхийг хориглоно.

3.10. Саатуулагдсан хүнийг түүнийг саатуулах тухай шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан, хяналтын прокурор, түүнтэй гэрээ байгуулан ажиллаж буй албан ёсны өмгөөлөгчтэй өглөөний 08 цагаас оройн 22 цагийн хооронд уулзуулна.

3.11. Саатуулагдсан хүнд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж болон эмнэлгийн үйлчилгээг цаг хугацаа харгалзахгүй үзүүлэх ба авагдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хийгдсэн эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн ажилтны талаарх мэдээллийг нарийвчлан авч тэмдэглэл, бүртгэл хөтөлж, тухайн хүний хувийн хэрэгт хавсаргана.

Дөрөв. Саатуулагдсан этгээдийг хүлээн авах

4.1. Саатуулагдсан хүнийг саатуулах байранд өдөр, шөнийн аль ч цагт холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн хамт хүлээн авах ба түүнд эмчийн үзлэг хийж, гэрэл зураг /эгц урдаас, хажуу талаас нь болон онцлох содон шинж, шарх, сорив г.м/-ийг нь авч баримтжуулан, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулна.

4.2. Саатуулагдах хүнд эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай бол саатуулах байранд хүлээж авахаас татгалзаж болно.

4.3. Саатуулагдахаар хүргэгдэн ирсэн хүн нь согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэл нөлөөт бодис хэрэглэсэн, сэтгэцийн өвчтэй нь илтэд мэдэгдсэн үед уг хүнийг эрүүлжүүлэх байранд шилжүүлэх, эсхүл эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авна.

4.4. Согтуурах, мансуурах донтой болон сэтгэцийн өвчтэй хүнийг саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд 6 цаг хүртэл хугацаагаар саатуулах байранд хүлээн авсан тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, саатуулах байрны хамгаалалт, хяналтыг нэмэгдүүлнэ.

4.5. Саатуулагдаж буй хүнд тэмдэглэлийг танилцуулж, гарын үсэг зуруулсан үеэс саатуулах хугацааг эхлэн тоолно.

4.6. Саатуулагдах хүнийг анх хүлээн авах, саатуулах байрнаас түр гарч яваад ирэх бүрт үзлэг хийж, саатуулах өрөөнд авч орохыг зөвшөөрөөгүй зүйл илэрсэн тохиолдолд тэмдэглэл хөтлөн түр хураан авах бөгөөд уг хүнийг хүргэж ирсэн эрх бүхий албан тушаалтанд тэмдэглэлийн хувийн хамт хүлээлгэн өгнө. Хүлээлгэн өгөх боломжгүй бол саатуулах байрны холбогдох албан тушаалтан /жижүүр/ хураан авсан тэмдэглэлийн хамт хадгалах ба саатуулагдсан хүнийг суллагдах үед нь тэмдэглэлд гарын үсэг зуруулан хүлээлгэж өгнө.

4.7. Саатуулагдсан хүнийг хүлээн авах байрны эрх бүхий албан тушаалтан нь дараах үйл ажиллагаа явуулна:

4.7.1. Саатуулах байрны ажилтан саатуулагдсан хүнийг хүргэж ирсэн эрх бүхий албан тушаалтныг байлцуулан үзлэг хийж, саатуулах өрөөнд авч орохыг хориглосон зүйлс илэрвэл саатуулах тэмдэглэлд тодорхой бичиж, тэдгээрийг хураан авч, уг саатуулагдсан хүнийг хүргэж ирсэн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх, эсхүл түр хураан авч, тэмдэглэлийн хамт хадгалах, гэмтэл, шарх, сорви байгаа бүртгэлд тодорхой тэмдэглэх;

4.7.2. Саатуулагдсан хүний биед ижил хүйсийн ажилтан үзлэг хийх ба ижил хүйсийн ажилтан байхгүй байгаа тохиолдолд эмчээр үзлэг хийлгэх;

4.7.3. Саатуулах байрны ажилтан саатуулагдсан хүний овог нэр, байнга оршин суух хаяг, саатуулагдсан үндэслэл, эхлэх, дуусах хугацаа, хүргэж ирсэн алба хаагчийн албан тушаал, утас, нэрийг тусгасан бүртгэл хөтлөх;

4.7.4. Саатуулагдсан тодорхой хүнийг шүүхээс үндэслэлгүйгээр саатуулсан гэж үзэн суллах шийдвэр бичгээр өгвөл даруй гүйцэтгэх;

4.7.5. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчийг суллах тухай шийдвэр ирүүлээгүй тохиолдолд хугацаа дуусмагц тухайн байрны эрх бүхий албан тушаалтан саатуулсан албан тушаалтанд мэдэгдэж, зөрчлийн холбогдогчийг суллаж энэ тухай тэмдэглэл үйлдэх;

4.7.6. Саатуулагдсан хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай гэж үзсэн бол хугацаанаас нь өмнө түр гаргаж болно. Энэ тохиолдолд саатуулсан эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх;

4.7.7. Гал түймэр, усны үер, газар хөдлөлт, гэнэтийн аюул, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед саатуулагдсан хүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилгоор саатуулагдсан хүмүүсийг шилжүүлэх, суллах талаар саатуулах байрны даргын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

4.7.8. Саатуулагдсан хүнд үзлэг хийх, түүний эд зүйлийг хураан авах ажиллагааг холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах.

Тав. Саатуулагдсан этгээдийг түр гаргах, суллах

5.1. Саатуулагдсан хүнийг дор дурдсан тохиолдолд саатуулах байрнаас түр гаргана:

5.1.1. саатуулах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан уулзах, авч явах үед;

5.1.2. эмч, эмнэлгийн байгууллагын шийдвэрээр эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийлгэж, шинжилгээ өгөх, эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх үед;

5.2. Саатуулагдсан хүнийг саатуулах байрнаас түр гарган авч яваа эрх бүхий албан тушаалтан хамгаалалтыг өөрөө хариуцах ба буцааж хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ.

5.3. Саатуулагдсан хүнийг саатуулах байрнаас түр гарч яваад ирэх бүрт энэ журмын 4.6-д заасныг нэгэн адил баримтална.

5.4. Гал түймэр, усны үер, газар хөдлөлт зэрэг гэнэтийн аюулын үед саатуулагдсан этгээдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилгоор түр гаргах, нүүлгэн шилжүүлэх асуудлыг саатуулах байрны дарга бие даан шийдвэрлэнэ.

5.5. Саатуулах тухай тэмдэглэлд заасан хугацаа нь дуусмагц саатуулагдсан хүнийг суллана.

5.6. Прокуророос үндэслэлгүй саатуулагдсан гэж үзэн, суллах шийдвэрийг бичгээр ирүүлсэн тохиолдолд тухайн нэр бүхий саатуулагдсан хүнийг тэр даруй суллан гаргана.

5.7. Саатуулагдсан этгээдийг саатуулах байрнаас суллан гаргах тохиолдолд саатуулсан эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Саатуулах байр нь зөвхөн саатуулах тухай шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой үүрэг гүйцэтгэх бөгөөд эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх /саатуулагдсан хүний талаар гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь мэдэгдэх, хаана, ямар зөрчлийн учир, хэний шийдвэрээр, хэдий хугацаагаар саатуулагдсан тухай тодорхойлолт хийж өгөх зэрэг/ үүргийг саатуулах байрны захиргаа, жижүүрт шилжүүлэн хариуцуулахыг хориглоно.

6.2. Саатуулагдсан асуудалтай холбоотой гомдлыг прокурорт гаргана.

6.3. Саатуулагдсан хүнээс саатуулах байрны захиргаанд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтэд ажлын 6 цагт багтаан хариу өгнө.

6.4. Саатуулагдсан хүнээс төрийн дээд болон шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, албан тушаалтанд илгээх өргөдөл, гомдлыг байрны захиргаа хүлээн авч, саатуулагдсан хүний өөрийнх нь зардлаар шууд илгээнэ. Саатуулагдсан хүн зардлыг төлөх боломжгүй бол саатуулах байрны захиргаа төлж болно.

6.5. Энэ журмын 6.3 дугаар зүйлд дурдсанаас бусад бүх захидал, харилцааг тухайн хүнийг саатуулсан байгууллага, албан тушаалтнаар дамжуулна.

6.6. Саатуулах байранд дор дурдсан баримт бичгийг хөтөлнө:

6.6.1. жижүүрийн хоногийн мэдээ;

6.6.2. саатуулагдсан хүмүүсийн нэгдсэн бүртгэл;

6.6.3. саатуулагдсан хүний карт;

6.6.4. саатуулагдсан хүнээс эд зүйл түр хурааж авсан бүртгэл;

6.6.5. саатуулагдсан хүнээс гаргасан гомдол, хүсэлтийн бүртгэл;

6.6.6. саатуулах байранд нэвтэрсэн хүмүүсийн бүртгэл;

6.6.7. саатуулах байрнаас түр гаргасан хүмүүсийг бүртгэл;

6.6.8. саатуулагдсан хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж, эмнэлгийн болон эмчийн бусад тусламж үйлчилгээ үзүүлсэн, эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлсэн бүртгэл;

6.6.9. телекамерын хяналтын бүртгэл;

6.6.10. тусгай хэрэгсэл хүлээлцсэн болон албадлага хэрэглэсэн тухай бүртгэл, тэмдэглэл.

6.7. Саатуулах байрны дотоод журмыг хууль тогтоомж, энэ журамд нийцүүлэн саатуулах үйл ажиллагаа явуулах эрх бүхий төв байгууллага тогтоож мөрдүүлнэ.

---oOo---